



## МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2014 оны 3 сарын 31 өдөр

Дугаар A-56

Улаанбаатар хот

Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 460 дугаар тушаалаар батлагдсан “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын 1 дүгээр хавсралтад дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай.

- 1) Б10.8 “Хадгаламж барьцаалсан зээл”, “эрсдэлээр жигнэх хувийг 0 хувь”;
- 2) Б10.9 “Бусад зээл”, “эрсдэлээр жигнэх хувийг 100 хувь”.

2. Мөнгөн хадгаламж барьцаалж ижил валютаар олгосон, эргэн төлөлтийн нийт дүн нь барьцааны үлдэгдлээс хэтрээгүй зээлийг Б10.8-д хамруулсугай.

3. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар (Д.Ганбат)-т үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Н.ЗОЛЖАРГАЛ